ВИДЕО МЭДЭЭ · 2023 оны 1-р сарын 24

ШҮҮХЭД ТӨРИЙГ ТӨЛӨӨЛӨХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТООН МЭДЭЭ





- **Прокурорын эсэргүүцлээр хууль зөрчсөн, хуулийг буруу хэрэглэсэн шүүхийн 296 шийдвэрийг зөвтгүүллээ.**

Прокурор 2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны 14.326, давж заалдах шатны 2135, хяналтын шатны 155 шүүх хуралдаанд тус тус оролцож, дүгнэлт гаргажээ.

Мөн шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангуулах зорилгоор шүүх шийдвэр гаргахдаа хууль зөрчсөн, хуулийг буруу хэрэглэсэн тохиолдлуудад 724 эсэргүүцэл бичиж, шүүхээр хэлэлцүүлснээс 67 хувь нь биелсэн байна.

ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД ХИЙСЭН АЖИЛ, ГАРСАН ҮР ДҮН:

- **2022 онд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн санаачилгаар нэхэмжлэх**

гаргаж оролцсон оролцоо 48.9 хувиар өсөв.

Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар 2065 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн санаачилгаар оролцож, 54.8 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүллээ.

Түүнчлэн эрүүгийн болон зөрчлийн хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг гаргуулах 559 хэрэгт оролцож 591.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлэв.

Видео: https://www.youtube.com/watch?v=1HBZU2KtloE

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2101